

**КОМПАНИЙН НОГДОЛ
АШИГ ХУВААРИЛАХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Компанийн хувь нийлүүлэгчдийн эрх ашиг, санхүүгийн тогтвортой үйл ажиллагааг хангахад компанийн жилийн ашгийг зөв зохистой хуваарилаад **ЭНЭХҮҮ ЖУРМЫН ҮНДСЭН ЗОРИЛГО ОРШИНО.**

1.2 Компанийн жилийн цэвэр ашгийг:

1.2.1. Компанийн хувь нийлүүлэгчдэд олгох ногдол ашиг;

1.2.2. Компанийн нөөцийн сан;

1.2.3. Цалин урамшуулал болон иийгмийн хөгжлийн сан гэж гурав хуваана.

1.3. Компанийн жилийн санхүүгийн тайланг холбогдох хуулиудад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн зарчим жишиг, хугацааны дагуу гаргаж, эрх бүхий Аудитын байгууллагаар баталгаажуулан, харьяа татварын албатай ашгийн тооцоо хийж, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийн дагуу ашиг хуваарилна.

1.4. Компанийн санхүүгийн тайланг ТУЗ-ийн тогтоолоор батлагдсаны дараа жилд нэг удаа компанийн ашгийг хуваарилж, хувь нийлүүлэгчдэд олгох ба холбогдох сангуудад шилжүүлнэ.

ХОЁР . НОГДОЛ АШИГ БОДОХ

2.1. Хувь нийлүүлэгчдэд өгөх ногдол ашгийг хувь нийлүүлэгч нэг бүрийн нээсэн нэрийн данс буюу ҮЦТТХадгаламжийн дансанд шилжүүлнэ.

2.3. Компанийн жилийн цэвэр ашгаас хувь нийлүүлэгчдэд олгох нийт цэвэр ашгийн **тогтоосон хувийг** ногдол ашиг бодох нийт хувийн тоонд хувааж **нэг хувийн тоонд ногдох ашгийг** тодорхойлно.

2.4. Хувь нийлүүлэгч нэг бүрт олгох ашгийг, тухайн хувь нийлүүлэгчийн хувийн тоог **нэг хувийн тоонд ногдох ашгаар** үргүүлж гаргана.

ГУРАВ. НОГДОЛ АШИГ ОЛГОХ

3.1. Хувь нийлүүлэгчийн хурлаас заасан хугацааны дотор хувь нийлүүлэгчдэд ногдол шгийг бэлэн ба бэлэн бусаар олгоно.

3.2. Ногдол ашгийг бэлнээр олгоходо:

Дебет Өнгөрсөн оны ашиг
Кредит Касс

Дебет Өнгөрсөн оны ашиг
Кредит Харилцах буюу Хоорондын тооцооны данс гэж тус тус гүйлгээ хийнэ.

3.3. Компанийн жилийн цэвэр ашгаас компанийн Нөөцийн санд хөрөнгө хуваарилсан шийдвэрийг үндэслэн :

Дебет Өнгөрсөн оны ашиг
Кредит Нөөцийн сан гэж гүйлгээ хийнэ.

3.7. Компанийн жилийн цэвэр ашгаас компанийн Нийгмийн хөгжлийн санд хөрөнгө хуваарилсан шийдвэрийг үндэслэн :

Дебет Өнгөрсөн оны ашиг
Кредит Нийгмийн хөгжлийн сан гэж гүйлгээ хийнэ.